

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Шинжлэх ухаан, технологийн сангийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2024/16/НА-СТА-ЗГТС

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2023 он	Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: Д.Энхдалай Утас: 260512 Цахим хаяг: enkhdalaid@audit.gov.mn Ахлах аудитор: А.Даваадорж Утас: 261628 Цахим хаяг: davaadorja@audit.gov.mn Аудитор: М.Ганбаатар Утас: 261628 Цахим хаяг: ganbaatarm@audit.gov.mn Аудитор: Я.Марал-Эрдэнэ Утас: 261628 Цахим хаяг: maral-erdeneya@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2024.02.23 № 07/287

танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Шинжлэх ухаан, технологийн сангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Шинжлэх ухаан, технологийн сангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 3,613,629.4 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс өндөр бөгөөд Иргэний хуулийн 75 дугаар зүйлийн 75.2.1, 206 дугаар зүйлийн 206.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3-д заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Шинжлэх ухаан, технологийн сан нь шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэлийн онолын суурь судалгаа, шинжлэх ухаан, технологийн болон инновацын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, эрдэм шинжилгээний ажлын үр дүнг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэхэд санхүүжилт олгох, зарцуулсан хөрөнгийн ашиглалтад хяналт тавих, нэгтгэн тайлагнах үйл ажиллагаа явуулсан байна.

Шинжлэх ухаан, технологийн сангийн бүтэц, зохион байгуулалт, ажлын байрны чиг үүрэг, албан тушаалын тодорхойлолтод дүн шинжилгээ, оношилгоо хийх, дүгнэлт гаргах ажлыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэргэдэх Удирдлагын академиар гүйцэтгүүлж, уг дүгнэлтийг үндэслэн Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны А/324 тоот тушаалаар Шинжлэх ухаан, технологийн сангийн Ажлын албаны зохион

байгуулалтын бүтцийг батлуулж, бүх ажилтан, албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг шинэчилсэн байна.

Аудитын гол асуудал

Шинжлэх ухаан, технологи, инновацын ололт амжилтыг түгээн дэлгэрүүлэх, сурталчлах, эрдэм шинжилгээний ажлын үр дүнг үйлдвэрлэл үйлчилгээнд нэвтрүүлэх, орон нутгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор “Орон нутагт шинжлэх ухаан, технологи, инновацыг нутагшуулья” аяныг Говь-Алтай, Өвөрхангай, Завхан, Төв, Хэнтий аймагт, “Судлаач оюутнуудын шинжлэх ухаанч нөлөөллийн аян”-ыг 12 их, дээд сургууль, Эрдэм шинжилгээний байгууллагад зохион байгуулсан байна.

Аяны талаарх мэдээлэл болон Шинжлэх ухаан, танин мэдэхүйн “Science X” цуврал видео контентын 19 дугаарыг бэлтгэж Facebook, Youtube, Soundcloud, Mplus.mn зэрэг олон нийтийн мэдээллийн сувгууд, Шинжлэх ухаан, технологийн сан болон оролцогч байгууллагуудын цахим хуудсаар түгээсэн бөгөөд 20000 орчим хэрэглэгч үзэж сонирхсон байна.

Тайлант онд Шинжлэх ухаан, технологийн сангийн санхүүжилтээр их дээд сургууль, хүрээлэн, төвийн 70 гүйцэтгэгч байгууллагын үндсэн чиглэлийн 27, үргэлжлэн хэрэгжиж байгаа 371, нийт 398 төсөл хэрэгжиж, Шинжлэх ухаан, технологийн 186 төслийн тайлан, эрдэмтдийн 152 диссертацид “Эрдэм шинжилгээний ажлын тайланг итгэмжлэн хадгалагчид хүлээлгэн өгөх журам”-ын дагуу номзүйн техник боловсруулалт хийж, сангийн мэдээллийн баазад баяжилт хийсэн байна.

Мөн Шинжлэх ухаан, технологийн сангийн мэдээллийн баазад хадгалагдаж байгаа 3119 эрдэм шинжилгээний ажлын тайлан, 4260 эрдэмтдийн диссертацийг цахим хэлбэрт оруулах ажлыг мэргэжлийн байгууллагатай хамтран хэрэгжүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд Шинжлэх ухаан, технологийн салбарыг хөгжүүлэх талаар баримталж буй төрийн бодлого тогтвортой, оролцогч талуудын үйл ажиллагаа олон нийтэд ил тод, нээлттэй, шинжлэх ухаан, технологийн тэргүүлэх чиглэлд нийцсэн төсөл, хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлж, үр нөлөөг тооцож, хяналт тавьсан эсэхэд аудит хийж, аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн зөвлөмж боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулах зорилгоор Шинжлэх ухаан, технологийн сангийн 2020-2022 он, 2023 оны эхний хагас жилийн үйл ажиллагааг хамруулан Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-Нийцлийн аудитын газраас “Төрөөс шинжлэх ухаан, технологийн салбарын талаар баримталж буй бодлогын хэрэгжилт, үр нөлөө” сэдэвт гүйцэтгэлийн аудит хийсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	12,508,854,815.25	11,091,478,828.59
33	АВЛАГА	350,896,971.90	313,905,000.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	630,216.90	-
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	337,680,000.00	310,980,000.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	10,381,255.00	2,925,000.00
33500	Бусад авлага	2,205,500.00	-
33510	Байгууллагаас авах авлага	2,205,500.00	-
34	УРЬДЧИЛГАА	12,084,667,100.55	10,707,924,201.01
34600	Урьдчилж гарсан зардал	12,082,865,505.39	10,707,924,201.01
34710	Урьдчилгаа тооцоо	1,801,595.16	-
34711	Бараа материал бэлтгэх урьдчилгаа	1,801,595.16	-
35	БАРАА МАТЕРИАЛ	73,290,742.80	69,649,627.58
35100	Түүхий эд материал	25,458,000.00	-
35110	Тусгай зориулалттай материал	25,458,000.00	-
35400	Хангамжийн материал	47,832,742.80	69,649,627.58
35410	Бичиг хэргийн материал	6,740,152.00	9,666,050.00
35420	Аж ахуйн материал	1,916,407.30	2,573,530.54
35440	Түлш, шатах тослох материал	7,258,200.00	6,182,598.54
35470	Бусад хангамжийн материал	31,917,983.50	51,227,448.50
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	204,472,399.18	178,942,233.84
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	204,472,399.18	178,942,233.84
39200	Биет хөрөнгө	198,995,524.14	176,664,525.44
39203	Авто-тээврийн хэрэгсэл	4,450,000.00	-
39204	Хуримтлагдсан элэгдэл	(2,892,500.13)	-
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	196,726,719.30	228,102,759.30
39206	Хуримтлагдсан элэгдэл	(63,200,576.84)	(104,181,292.46)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	83,915,567.82	83,915,567.82
39208	Хуримтлагдсан элэгдэл	(27,993,204.76)	(39,162,027.97)
39217	Ном	7,989,518.75	7,989,518.75
39300	Биет бус хөрөнгө	5,476,875.04	2,277,708.40
39301	Програм хангамж	45,110,300.00	45,110,300.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(43,813,425.00)	(44,225,925.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	8,360,000.00	8,360,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(4,179,999.96)	(6,966,666.60)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	12,713,327,214.43	11,270,421,062.43
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	2,925,000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	2,925,000.00
41300	Өглөг	-	2,925,000.00
41360	Бусад өглөг	-	2,925,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	2,925,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	12,713,327,214.43	11,267,496,062.43
51	Засгийн газрын хувь оролцоо	12,713,327,214.43	11,267,496,062.43
51100	Засгийн газрын оруулсан капитал	123,479,820.74	-
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	123,479,820.74	123,479,820.74

Шинжлэх ухаан, технологийн сангийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

51200	Хуримтлагдсан үр дүн	12,589,847,393.69	11,144,016,241.69
51210	Өмнөх үеийн үр дүн	12,595,236,056.40	12,589,847,393.69
51220	Тайлант үеийн үр дүн	(5,388,662.71)	(1,445,831,152.00)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	12,713,327,214.43	11,270,421,062.43

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	10,097,933,924.00	13,437,906,978.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	44,883,860.00	31,376,040.00
120	Нийтлэг татварын бус орлого	44,883,860.00	31,376,040.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	44,883,860.00	31,376,040.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	10,053,050,064.00	13,406,530,938.50
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	10,011,207,682.00	13,361,666,253.50
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	10,011,207,682.00	13,361,666,253.50
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	41,842,382.00	44,864,685.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	41,842,382.00	44,864,685.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	10,103,322,586.71	14,883,070,630.67
21	УРСГАЛ ЗАРДАЛ	10,103,322,586.71	14,883,070,630.67
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	10,056,692,287.79	14,798,683,309.38
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	439,697,362.92	497,649,956.40
210101	Үндсэн цалин	326,473,126.40	326,134,285.74
210102	Нэмэгдэл	70,558,756.52	96,921,315.49
210103	Унаа хоолны хөнгөлөлт	30,766,000.00	54,381,436.57
210104	Урамшуулал	11,899,480.00	10,785,100.00
210105	Гэрээт ажлын хөлс	-	9,427,818.60
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	54,740,313.22	62,948,022.28
210201	Тэтгэврийн даатгал	37,760,900.95	43,246,922.54
210202	Тэтгэмжийн даатгал	4,442,456.07	5,063,599.24
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,517,004.99	3,998,078.85
210204	Ажилгүйдлийн даатгал	819,996.06	975,892.61
210205	Эрүүл мэндийн даатгал	8,199,955.15	9,663,529.04
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	133,724,500.00	170,235,952.00
210304	Байрны түрээс	133,724,500.00	170,235,952.00
2104	Хангамж, бараа материалын зардал	75,688,793.68	83,311,086.39
210401	Бичиг хэрэг	28,698,632.00	18,972,232.00
210402	Тээвэр, шатахуун	21,086,312.00	31,181,796.62
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	10,389,223.08	8,565,382.01
210404	Ном, хэвлэл	166,200.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	15,348,426.60	24,591,675.76
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	204,000.00	-
210604	Урсгал засвар	204,000.00	-
2107	Томилолт, зочны зардал	3,808,000.00	13,756,000.00

Шинжлэх ухаан, технологийн сангийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210702	Дотоод албан томилолт	3,808,000.00	13,756,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,262,821,758.07	13,836,576,596.80
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,235,366,016.07	13,818,228,896.80
210804	Тээврийн хэрэгслийн татвар	56,432.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	27,399,310.00	18,347,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	86,007,559.90	134,205,695.51
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	23,440,761.10	12,243,560.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	490,000.00	65,723,430.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	62,076,798.80	56,238,705.51
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	46,630,298.92	84,387,321.29
2132	Бусад урсгал шилжүүлэг	393,600.00	3,790,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	393,600.00	3,790,800.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	46,236,698.92	80,596,521.29
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	46,139,412.22	-
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	97,286.70	8,682,740.00
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	-	71,913,781.29
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(5,388,662.71)	(1,445,163,652.17)
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	667,499.83
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	-	667,499.83
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(5,388,662.71)	(1,445,831,152.00)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	10,100,709,412.70	13,474,537,193.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	45,044,979.00	57,625,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	45,044,979.00	57,625,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	45,044,979.00	57,625,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	2,925,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	45,044,979.00	54,700,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	10,055,664,433.70	13,416,912,193.50
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	10,011,207,682.00	13,361,666,253.50
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	10,011,207,682.00	13,361,666,253.50
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	44,456,751.70	55,245,940.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	44,456,751.70	55,245,940.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	10,097,630,612.70	13,474,537,193.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	10,097,630,612.70	13,474,537,193.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	10,040,619,058.78	13,387,224,872.21
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	337,112,171.85	438,926,175.33
210101	Үндсэн цалин	224,520,951.65	247,504,436.39
210102	Нэмэгдэл	69,967,743.20	119,329,170.71
210103	Унаа хоолны хөнгөлөлт	30,723,997.00	54,077,436.57
210104	Урамшуулал	11,899,480.00	9,385,144.39
210105	Гэрээт ажлын хөлс	-	8,629,987.27
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	44,471,876.19	52,884,100.00
210201	Тэтгэврийн даатгал	30,587,923.67	35,961,000.00
210202	Тэтгэмжийн даатгал	3,839,913.38	4,230,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,678,407.58	3,384,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	668,242.82	846,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,697,388.74	8,461,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	133,724,500.00	170,235,952.00
210304	Байрны түрээс	133,724,500.00	170,235,952.00
2104	Хангамж, бараа материалын зардал	25,214,670.85	23,779,671.01
210401	Бичиг хэрэг	4,715,100.00	6,975,900.00
210402	Тээвэр, шатахуун	7,338,200.00	6,761,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,060,580.85	8,535,382.01
210404	Ном, хэвлэл	166,200.00	119,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,934,590.00	1,387,789.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	574,800.00	281,700.00
210604	Урсгал засвар	574,800.00	281,700.00
2107	Томилолт, зочны зардал	3,808,000.00	13,756,000.00
210702	Дотоод албан томилолт	3,808,000.00	13,756,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,495,223,039.89	12,621,637,843.87
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,482,528,097.89	12,615,047,643.87
210804	Тээврийн хэрэгслийн татвар	56,432.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	12,638,510.00	6,590,200.00

Шинжлэх ухаан, технологийн сангийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	490,000.00	65,723,430.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	490,000.00	65,723,430.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	57,011,553.92	87,312,321.29
2132	Бусад урсгал шилжүүлэг	393,600.00	3,790,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	393,600.00	3,790,800.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	56,617,953.92	83,521,521.29
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	46,139,412.22	2,925,000.00
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	10,478,541.70	8,682,740.00
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	-	71,913,781.29
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	3,078,800.00	-
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	3,078,800.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,078,800.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	3,078,800.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	3,078,800.00	-
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(3,078,800.00)	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	123,479,820.74	-	12,595,236,056.40	12,718,715,877.14
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	123,479,820.74	-	12,595,236,056.40	12,718,715,877.14
9	Тайлант үеийн үр дүн	-	-	(5,388,662.71)	(5,388,662.71)
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	123,479,820.74	-	12,589,847,393.69	12,713,327,214.43
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	123,479,820.74	-	12,589,847,393.69	12,713,327,214.43
19	Тайлант үеийн үр дүн	-	-	(1,445,831,152.00)	(1,445,831,152.00)
20	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	123,479,820.74	-	11,144,016,241.69	11,267,496,062.43

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	13,387,877,700.00	13,344,452,472.21	43,425,227.79	99.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	13,387,877,700.00	13,344,452,472.21	43,425,227.79	99.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	13,357,875,500.00	13,340,661,672.21	17,213,827.79	99.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	442,577,300.00	438,926,175.33	3,651,124.67	99.2
210101	Үндсэн цалин	296,698,000.00	247,504,436.39	49,193,563.61	83.4
210102	Нэмэгдэл	108,264,800.00	119,329,170.71	11,064,370.71	110.2
210103	Унаа хоолны хөнгөлөлт	22,176,000.00	54,077,436.57	31,901,436.57	243.9
210104	Урамшуулал	15,438,500.00	9,385,144.39	6,053,355.61	60.8
210105	Гэрээт ажлын хөлс	-	8,629,987.27	(8,629,987.27)	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	52,884,100.00	52,884,100.00	-	100.0
210201	Тэтгэврийн даатгал	35,961,000.00	35,961,000.00	-	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	4,230,500.00	4,230,500.00	-	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,384,500.00	3,384,500.00	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	846,300.00	846,300.00	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	8,461,800.00	8,461,800.00	-	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	170,236,000.00	170,235,952.00	48	100.0
210304	Байрны түрээс	170,236,000.00	170,235,952.00	48	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	11,262,000.00	10,902,471.01	359,528.99	96.8
210401	Бичиг хэрэг	2,573,900.00	2,573,900.00	-	100.0
210402	Тээвэр, шатахуун	850,700.00	-	850,700.00	
210403	Шуудан, холбоо, интернэгийн төлбөр	6,509,400.00	7,741,182.01	(1,231,782.01)	118.9
210404	Ном, хэвлэл	262,200.00	119,000.00	143,200.00	45.4
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,065,800.00	468,389.00	597,411.00	43.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	281,700.00	281,700.00	-	100.0
210604	Урсгал засвар	281,700.00	281,700.00	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	12,613,480,000.00	12,601,707,843.87	11,772,156.13	99.9
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,606,889,800.00	12,595,117,643.87	11,772,156.13	99.9
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,590,200.00	6,590,200.00	-	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	67,154,400.00	65,723,430.00	1,430,970.00	97.9

Шинжлэх ухаан, технологийн сангийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	67,154,400.00	65,723,430.00	1,430,970.00	97.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	30,002,200.00	3,790,800.00	26,211,400.00	12.6
2132	Бусад урсгал шилжүүлэг	30,002,200.00	3,790,800.00	26,211,400.00	12.6
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	22,116,400.00	-	22,116,400.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,885,800.00	3,790,800.00	4,095,000.00	48.1
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	13,387,877,700.00	13,347,377,472.21	40,500,227.79	99.7
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	13,387,877,700.00	13,289,752,472.21	98,125,227.79	99.3
310001	Улсын төсвөөс санхүүжих	13,387,877,700.00	13,289,752,472.21	98,125,227.79	99.3
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	57,625,000.00	57,625,000.00	-
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	57,625,000.00	57,625,000.00	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0
610001	Төсвийн байгууллага	1	1	-	100.0
610002	Төсвөөс гадуур байгууллага	-	-	-	
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	24	24	-	100.0
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	22	22	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	1	1	-	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		55,245,940.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		55,245,940.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		46,563,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал		12,877,200.00
210401	Бичиг хэрэг		4,402,000.00
210402	Тээвэр, шатахуун		6,761,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		794,200.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		919,400.00
2107	Томилолт, зочны зардал		13,756,000.00
210702	Дотоод албан томилолт		13,756,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		19,930,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		19,930,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		8,682,740.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		8,682,740.00
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		8,682,740.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		55,245,940.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		55,245,940.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		55,245,940.00

АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Аудитаар нийт 169,215.6 мянган төгрөгийн 3 алдаа¹ илэрснийг аудитын явцад залрууллаа.

/мянган төгрөгөөр/

д/д	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Гэрээний үүрэг зөрчигдөн цаашид хэрэгжих үндэслэлгүй болсон 2 төслийн санхүүжилт 28,000.0 мянган төгрөг буцаж орж ирснийг Санхүүгийн үр дүнгийн тайланд туслах үйл ажиллагааны орлогоор бүртгэсэн, 48,712.3 мянган төгрөгийн зардал бууруулах бичилт хийсэн байна.	1	76,712.3			1	76,712.3	1	76,712.3				
2	Төсвийн гүйцэтгэлийн тайланд төвлөрүүлэх шилжүүлэг болон нэр данс зөрүүгийн орлогыг цэвэрлэж тайлагнаагүй байна.	1	77,763.8			1	77,763.8	1	77,763.8				
3	Тусгай зориулалтын материалын дансанд 14,739.5 мянган төгрөгийн хангамжийн материал бүртгэсэн байна.	1	14,739.5			1	14,739.5	1	14,739.5				
	Дүн	3	169,215.6			3	169,215.6	3	169,215.6				

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Шинжлэх ухаан, технологийн сангийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Аудитаар санхүүгийн тайлагналтай холбоотой нийт 3,997,720.9 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 3,925,366.3 сая төгрөгийн зөрчилд 10 албан шаардлага хүргүүлж, 72,354.6 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

/мянган төгрөгөөр/

д/д	Зөрчлийн товч утга	Үүнээс											
		Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
1	Шинжлэх ухаан технологийн сангийн 2023 оны санхүүгийн тайланг бэлтгэхдээ Дотоод, гадаад албан томилолт болон гэрээний төлбөр 74,365.6 мянган төгрөгийг тооцооны дансаар дамжуулалгүй шууд зардлаар бүртгэсэн байна	1	74,365.6			1	74,365.6						
2	Их дээд сургууль, шинжлэх ухааны байгууллагуудын удирдлагууд, санхүүгийн албан хаагчдад зориулан Боловсрол, шинжлэх ухааны яамны дотоод аудитын хорооны 2023 оны 07 дугаар тогтоолоор өгсөн зөвлөмжийг хэрхэн хэрэгжүүлэх талаар болон салбарын хэмжээнд шинэчлэгдэн батлагдсан эрх зүйн баримт бичиг, журмуудыг танилцуулах, хэрэгжилтийг сайжруулах зорилгоор төсвийн жил дамнуулан 2 байгууллагатай сургалт зохион байгуулах гэрээ байгуулж, 32,378.7 мянган төгрөгийн урьдчилгаа олгосон байна	1	32,378.7			1	32,378.7						

Шинжлэх ухаан, технологийн сангийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

3	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлын төсвөөс эдийн засгийн ангилал зөрчин төсвийн төсөлд тусаагүй Олон улсын хурал зөвлөгөөнд оролцох зориулалт бүхий 38,146.3 мянган төгрөгийн гадаад томилолтын зардал гаргасан.	1	38,146.3			1	38,146.3						
4	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2008 оны 167 дугаар тушаалаар батлагдсан "Шинжлэх ухаан технологийн Зэхэц ажлыг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, санхүүжүүлэх, үр дүнг тооцох журам"-ын хүрээнд олгосон 8 харилцагчийн 5-аас дээш жилийн насжилттай, барьцаа хөрөнгөөр баталгаажаагүй 285,980.0 мянган төгрөгийн эргэн төлөгдөх нөхцөлтэй зээлийн хөөн хэлэлцэх хугацаа дууссан, найдваргүй болох эрсдэлтэй байна	1	285,980.0			1	285,980.0						
5	Тендер шалгаруулалт зохион байгуулалгүй нийт 29,700.0 мянган төгрөгийн шууд гэрээ байгуулсан	1	29,700.0			1	29,700.0						
6	Бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгож, нээлттэй тендер шалгаруулалт зохион байгуулалгүй 403,104.0 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн	1	403,104.0			1	403,104.0						
7	Тайлант онд хэрэгжиж дуусах Суурь судалгааны 11, Гадаадтай хамтарсан 47, Улсын захиалгат 6, нийт 2,850,341.4 мянган төгрөгийн 64 төсөл санд тайлан хүлээлгэн өгөх явц удаашралтай, хугацаандаа тайлангаа ирүүлээгүй, огт тайлан ирүүлээгүй зэрэг шалтгаанаар гэрээний үүрэг зөрчигдөж, хаагдаагүй байна	1	2,850,341.4			1	2,850,341.4						

Шинжлэх ухаан, технологийн сангийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

8	Тайлант онд хаасан 32 төслөөс 7 нь анхан шатны баримтын бүрдэл дутуу, 2 нь үйл ажиллагааны чиглэл өөр компаниар ажил гүйцэтгүүлсэн, 3 нь зардлын дээд хязгаараас хэтрүүлсэн нийт 189,390.3 мянган төгрөгийн зөрчил гаргасан	1	189,390.3			1	189,390.3						
9	“Нүүрсний давирхайнаас түлш, шатахуун болон замын битумын чанар сайжруулах нэмэлт гарган авах судалгаа” сэдэвт төслийн удирдагч өөрийн эзэмшлийн компаниас 21,960.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсан байна	1	21,960.0			1	21,960.0						
10	Төсөл хэрэгжүүлэх, санхүүжүүлэх гэрээний 5 дугаар хавсралтаар эрдэм шинжилгээний зардлыг ангилал тус бүрээр задлан баталдаг боловч төслүүдийн ажлын гүйцэтгэлийг шалгахад 80 гаруй хувь нь зардлыг гүйлгэн зарцуулсан	1	-			1	-						
11	Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа 40 нэр төрлийн 69,429.6 мянган төгрөгийн дансны үнэ бүхий хөрөнгийг бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгээгүй, шинэчлэн тогтоох саналыг ТӨБЗГ-т хүргүүлж, шийдвэрлүүлээгүй байна	1	69,429.6					1	69,429.6				
12	Тайлант хугацаанд төсөл, арга хэмжээтэй холбоотой 2,925.0 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэж, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй нь	1	2,925.0					1	2,925.0				
	Дүн	12	3,997,720.9	0	0	10	3,925,366.3	2	72,354.6				

Шинжлэх ухаан, технологийн сангийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар нийт 7 зөрчил илэрснээс 789,000 .0 мянган төгрөгийн 5 зөрчилд албан шаардлага, Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр болон архив, албан хэрэг хөтлөлтийн асуудлаар 2 зөвлөмж өглөө.

/мянган төгрөгөөр/

Д/д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
				Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
1	Шинжлэх ухаан, технологийн сангийн захирал нь тайлант онд дээд шатны төсөв захирагчтай үр дүнгийн гэрээ байгуулаагүй, хагас, бүтэн жилээр дүгнүүлээгүй	1	-	1			
2	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан боловсруулж, батлуулаагүй, хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлан мэдээлээгүй	1	-	1			
3	Хуулиар олгосон орлогын эх үүсвэр бүрдүүлэх, нэмэлт орлого олох талаар ажил зохион байгуулаагүй байна	1	-	1			
4	Тайлант онд шинээр хэрэгжиж эхэлсэн нийт 198,000.00 мянган төгрөгийн "Цэргийн зориулалттай СПЕКТР хэт богино долгионы үүргэвчийн радио станцыг сайжруулан шинэчлэх" төслийн удирдагч нь магистрын зэрэгтэй байна.	1	198,000.0	1	198,000.0		
5	Шинжлэх ухаан, технологийн сан нь тайлант онд төслийн сонгон шалгаруулалт хийхдээ өмнө хэрэгжүүлсэн төслийн үр дүнг хүлээлгэн өгөөгүй 8 төслийн удирдагчийг дахин шалгаруулсан	1	591,000.0	1	591,000.0		
6	Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлээгүй байна.	1	-			1	-
7	Архивын өрөө нь Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль болон түүнд нийцүүлэн гаргасан стандартад нийцээгүй, цахим архив үүсгээгүй, байгуулагдсан цагаас улсын төв архивд баримтаа шилжүүлээгүй, баримт бичиг устаж алга болох эрсдэлтэй байна.	1	-			1	-
	Дүн	7	789,000.0	5	789,000.0		